



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

Нийтийн тээврийн үйлчилгээний
чиглэлд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын “Дүрэм”-ийн 2.5.3, 3.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны иргэдийн зорчих эрэлт хэрэгцээг үндэслэж Ч47 “Орбит-Ард кинотеатр” чиглэлийг сунгаж замналыг хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх үйлчилгээг 2017 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс мөрдөж эхлэх чиглэлийн зураглал, үйлчилгээний цагийн хуваарийг боловсруулж, нэгдсэн даалгаварт тусгахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээний хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулж, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т, тухайн чиглэлийн үйлчилгээг зохион байгуулж, зохицуулалт хийх, хэвийн ажиллагааг хангуулж ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулах, ажиллах цагийн хуваарийн мөрдөлтөд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/25 дугаар тушаалын 53 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Д.ОТГОНБААТАР



1115708253 ... 211030

D:\alban khereg\Явсан бичиг 2017\TUSHAAI.docx

1150500334

